Ус ашиглуулагчийг төлөөлж Дорноговь аймгийн Байгаль орчны газрын Усны нөөц, ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн Ширнэн овогтой Амгалансайхан, Ус ашиглагчийг төлөөлж Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах улсын бүртгэлийн дугаар 9019085092 тоот гэрчилгээ, 5294088 тоот регистрийн дугаартай "Билэгт баялаг" ХХК-ийн Уурхайн ерөнхий инженер Батсайхан овогтой Сандагдорж нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон хүн амын унд ахуйн хэрэгцээнд усны нөөцийг ашиглана.

2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1. унд-ахуйд 4860,0 м³ /жил/

2.2.2. уурхайгаас шавхан зайлуулах 20979,0 м³ /жил/

2.3. Усны чанар, найрлага: Гүний худгийн уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн шинжилгээний хариу болон дүгнэлтийг тухай бүрт нь Байгаль орчны газарт ирүүлнэ.

2.4. Усны эх үүсвэр болон байршил: Гидрогеологийн өрөмдлөгийн мэдээлэл болон гидрогеологийн нөхцлөөс харахад усны эрдэсжилт нь 2,0 г/л бөгөөд ундны усны үндсэн шаардлагыг хангахгүй, зонхилон сульфат-хлорын найрлагатай, одоогоор ундны усыг Даланжаргалан сумаас зөврөөр ашигладаг. Зам талбайн тоосжилт дарахад уурхайн шүүрлийн ус ашиглана.

Барилга байгууламж: Байхгүй.

Тоног төхөөрөмжийн нэр, марк:

2.5.Хаягдал усны хэмжээ: Унд ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

Хаях цэгийн байршил: Солбилцол, байршлын мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Хаягдал бохир уснаас улирал тутам дээж авч усны биохимийн шинжилгээний дүнг тухай бүрт нь Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

Жинлэгдэх бодис, кг.....

Органик бодис, кг.....

Эрдэс бодис, кг.....

Хүнд металл, кг.....

Аюултай бохирдуулах бодис, гр.....

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Унд ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төлөвлөж ирүүлнэ.

2.9. Усны тоолуур: Усны эх үүсвэрүүдэд Стандартчилал хэмжилзүйн газраар баталгаажуулсан тоолуурыг суурилуулж тоолуурын заалтын дагуу усны нөөцийн төлбөр тооцоог хийх

Төрөл, нэр, дугаар:

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Дүгнэлт 14-д заасны дагуу нийт 25839,0м³ усны нөөцийн төлбөр 19060920,0 төг /арван есөн сая жаран мянга есөн зуун хорин төгрөг/

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, шинжилгээний үзүүлэлт, экологийн паспорт хөтлөх /MNS 4219-94/ Засгийн газрын тогтоол, төлбөр тооцох аргачлал нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний 2.3, 2.4, 2.6, 2.7, 2.8 дахь заалтуудад заагдсан чанар, найрлага, байршил, бохирдуулах бодисын хэмжээ, хаягдал ус хаях цэгийн байршил, ус хамгаалах арга хэмжээний талаарх мэдээллийг тусгайлан гаргаж Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

4.4. Ус ашиглуулагч нь 2025 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.5. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.


4.6. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.6.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;


4.6.2 аль нэг тал татан буугдсан бол.

4.7. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж
Байгаль орчны газрын усны нөөц,
ашиглалт, хамгаалалт хариуцсан
мэргэжилтэн  /Ш.Амгалансайхан/

Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд хот,
Төрийн өмчийн 3-р байр, 2 давхарт 206 тоот
Харилцах утас: 90990887

Ус ашиглагчийг төлөөлж
"Билэгт баялаг" ХХК-ийн
Уурхайн ерөнхий инженер
 /Б.Сандагдорж/

Хаяг: Дорноговь аймаг,
Даланжаргалан сум
Харилцах утас: 88034232



Умард говийн гүвээт-Халхын дундад талын

ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2025 оны 09 -р сарын 02 -ны өдөр

Дугаар Е-2505-000070

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

Оноосон нэр:	Билэгтбаялаг
Улсын бүртгэлийн дугаар:	
Регистрийн дугаар:	5294088
Захирал:	Энхзаяа
Холбоо барих дугаар:	99117230

1.2. Төслийн нэр, байршил:

Төслийн нэр:	Алаг тогоогийн чулуун нүүрсний ордын Зүүн далангийн хэсэг
Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт:	
Байршил:	Дорноговь, Даланжаргалан, 1-р баг, Элдэв
Дэлгэрэнгүй хаяг:	Дорноговь, Даланжаргалан, 1-р баг, Элдэв, 13-3
Харьяалагдах сав газар:	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар

Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл

2.1. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин

Хаягдал ус нийлүүлэх хэлбэр:	Байгальд нийлүүлэх
Нийлүүлж буй хаягдал усны төрөл:	
Нэмэлт тайлбар:	Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А/156 дугаар тушаалаар баталсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах - "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартаас давсан бол "Усны тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах.

2.2. Хаягдал усны хэмжээ

Хаягдал ус нийлүүлэх байгууламж	Хүчин чадал	Хаягдал усны төрөл	Хаягдал ус хаях зайлуулах цэг	Нийлүүлэлт	Цэвэрлэгээний арга	Тайлбар
Унд ахуйн хаягдал ус	4тн	[Унд ахуйн хаягдал ус]	Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд		Цэвэрлэдэггүй	1. Тус компанийн хаягдал усны хэмжээг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны 2025 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн Е-2505-000054 дугаартай ус ашиглуулах дүгнэлтээр гаргасан унд, ахуйн хэрэгцээнд ашиглах 4860м3/жил-ийг үндэслэв.

2.3. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл

2025 он

Лабораторийн шинжилгээний дүнгээр тооцсон бохирдуулах бодисын хэмжээ

Стандарт: S_MNS4943

Шинжилгээний давтамж: 1

№	Бохирдуулах бодисын төрөл	ЗДХ, (мг/л)	Хаягдал усны холимог дээж дэх бохирдуулах бодисын дундаж агууламж, (мг/л)	ЗДХ-ээс дахин хэтэрсэн агууламж	Нөхөн төлбөр тооцох шатлан өсгөх хэлбэр
---	---------------------------	-------------	---	---------------------------------	---

Жишиг хэмжээгээр тооцсон бохирдуулах бодисын хэмжээ

№	Үйл ажиллагаа	ЗДХ, (мг/л)
1	Нийгмийн үйлчилгээ болон бусад	
2	Үйлдвэрлэл	
3	Үйлчилгээ	
	Зочид буудал, Жуулчны бааз, Ажилчдын тосгон	1.5

Гурав. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ

3.1. Ус бохирдуулсны төлбөр тооцсон үндэслэл

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 баталсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал"

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/635 тоот тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны А-816/218 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"

3.2. Ус бохирдуулсны төлбөрийн тооцоо

Огноо	Улирал	Хаягдал усны	Тооцсон хаягдал	Төлбөр, тооцоо, ₮	Чөлөөлөлт дүн, ₮	Хөнгөлөлтийн дүн, ₮	Нийт төлбөр зохих
-------	--------	--------------	-----------------	-------------------	------------------	---------------------	-------------------

	төрөл	усны хэмжээ	дүн, ₮			
2025	-	4,860.00	364,500.00	0.00	0.00	364,500.00
Нийт			364,500.00	0.00	0.00	364,500.00

Дөрөв. Тавигдах шаардлага

"Усны тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалтад заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргатай байгуулсан "Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ"-г дүгнүүлж, сунгуулах

- "Усны тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас олгосон "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг"-ийг сунгуулах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлэх;
- Хаягдал ус хаях цэгийн байршлыг тогтоолгож Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГ-аас зөвшөөрөл авах
- Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх ба хугацаанд нь төлөөгүй тохиолдолд "Зөрчлийн тухай" хуулиар хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарах;
- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээг дүгнэсэн акт, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Uмарdgobi14@gmail.com цахим хаягаар 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Боловсруулсан:

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН

САВ ГАЗАР

З.Отгончимэг



Боловсруулсан огноо:

2025.09.02

Байгууллагын нэр: Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа

Газар хэлтэс:

Захиргаа

Албан тушаал:


Дарга

Овог нэр:

Батсүх Отгонсүрэн

Зурсан огноо:

2025.09.02 15:15:57

 Огноо/Date: 2025-10-30 12:19:34

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын /Journal No: 13658029

Системийн огноо/System Date: 2025-10-30 12:18:08

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5030242018	ЭРДЭНЭ ЭНХЗАЯА	19,060,920.00 MNT	1.00

Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК	Дүн/Amount	Ханш/Rate
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	19,060,920.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
3251005416033; ЧС76032705; 99999979

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers


Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

 **ХААН БАНК** Огноо/Date: 2025-10-29 20:55:08

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын /Journal No: 45059983

Системийн огноо/System Date: 2025-10-29 20:53:56

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5030242018	ЭРДЭНЭ ЭНХЗАЯА	273,375.00 MNT	1.00

Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК	Дүн/Amount	Ханш/Rate
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	273,375.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
1251003859657; ЧС76032705; 99999979

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

ХААН БАНК Огноо/Date: 2025-10-29 21:08:01

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын /Journal No: 15749575

Системийн огноо/System Date: 2025-04-14 12:23:36

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5071336102	БИЛЭГТ БАЯЛАГ	2,400,000.00 MNT	1.00

Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК	Дүн/Amount	Ханш/Rate
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	2,400,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
2250404218173; 5294088; 00000000

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

БАТЛАВ:

БАТЛАВ:

"БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.ЭНХЗАЯА



"ДАЛАН ТУЛГА МАЙНИНГ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.МӨНХТУЛГА



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАЛАНЖАРГАЛАН СУМ ЭЛДЭВ БАГААС
ТӨМӨР ЗАМЫН 25-Р ЗӨРЛӨГ ЧИГЛЭЛД САЙЖРУУЛСАН ШОРООН 20
КМ АВТО ЗАМЫН УРСГАЛ ЗАСВАР ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2025 оны 05 дугаар сарын 01-ны өдөр

№- 25/05

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн нэг талаас Монгол Улс, Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багт байрлах, 5294088 регистрийн дугаартай "Билэгт баялаг" ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Э.Энхзаяа (цаашид "Захиалагч" гэх),

Нөгөө талаас Монгол Улс, Дорноговь аймгийн Даланжаргалан сум, Олон овоо баг, Майхан-Овоо 4,429а тоот хаягт байрлах "ДАЛАН ТУЛГА МАЙНИНГ" ХХК-ийг РД:/3330001/ төлөөлөлж Захирал Б.Мөнхтулга (цаашид "Гүйцэтгэгч" гэх, хамтад нь "Талууд" гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Даланжаргалан сум Элдэв багаас Төмөр замын 25-р зөрлөг чиглэлийн нүүрс тээвэрлэлтийн 20-н км сайжруулсан шороон замын их засвар, шинэчлэлийн ажил (цаашид "Ажил" гэх)-ыг гэрээнд заасанд хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ. Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Гүйцэтгэгч нь Даланжаргалан сум Элдэв багаас Төмөр замын 25-р зөрлөг чиглэлийн нүүрс тээвэрлэлтийн 20-н км сайжруулсан шороон замын их засвар, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхдээ энэхүү гэрээ болон Авто замын тухай хууль, холбогдох дүрэм журам, норм стандартыг мөрдөж, хэрэгжүүлж ажиллана.

1.3. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

1.3.1. Хавсралт №1 Ажлын даалгавар;

1.3.2. Хавсралт №2 Гүйцэтгэгчийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

1.3.3. Хавсралт №4 Гүүр хоолойн зураг төсөв.

1.3.4. Хавсралт №5 Зам засварын үнийн задаргаа.

1.4. Гүйцэтгэгч нь ажлыг энэхүү гэрээний салшгүй баримт бичиг болох 1.3.1-д тодорхойлсон Ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэнэ.

1.5. Гүйцэтгэгч нь Ажлыг гэрээний хугацаанд хийж гүйцэтгэн Захиалагчид актаар хүлээлгэн өгнө.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ХЯНАЛТЫН ХЭЛБЭР,
ТАВИГДАХ ШААРДЛАГУУД**

2.1. Гэрээний хугацаа: Энэхүү Гэрээ нь 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 01 -ны өдрийг дуустал 60 хоногийн хугацаатай байна. Шаардлагатай гэж үзвэл гэрээт ажлын хугацааг сунгаж болох бөгөөд энэ тухайд талууд харилцан тохиролцоно.

- 2.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгч болно.
- 2.2. Ажлын хамрах хүрээ (Ажлын үр дүн): Гүйцэтгэгч нь Гэрээний Хавсралт N-°1-т заасан "Ажлын даалгавар"-ын дагуу Ажлыг гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгнө. Захиалагч нэг талын санаачлагчаар гүйцэтгэх ажлын хамрах хүрээ, бусад баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 2.3. Чанарын шаардлага: Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл нь үнэн зөв, бодитой, мэргэжлийн өндөр түвшинд байх шаардлагатай ба энэхүү гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.
- 2.4. Стандарт: Гүйцэтгэгч нь Ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын хэмжээнд болон олон улсад мөрдөгдөж байгаа Авто замын үйлчилгээтэй холбоотой бүх стандарт, норм, дүрмийг баримтлан ажиллана.
- 2.5. Гомдлын шаардлага гаргах хугацаа (Баталгаат хугацаа): Гүйцэтгэгчийн Ажлын гүйцэтгэл, үр дүнд ямар нэгэн доголдол байвал "Ажил хүлээлцэх акт"-ыг Талууд хамтран үйлдсэн өдрөөс хойш 3 сарын дотор Захиалагч нь гомдлын шаардлага гаргаж болно. Энэ хугацаанд Ажлын гүйцэтгэлд ямар нэг доголдол гарсан бол ажлын 10 (арав) хоногт эсвэл Захиалагчийн тогтоосон хугацаанд тухайн доголдлыг арилгах ба үнэ төлбөргүй гүйцэтгэнэ.
- 2.6. Ажлын гүйцэтгэл, чанарт захиалагч талууд ажлын хэсэг гарган хяналт тавина

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Төлбөр: 20 км шороон замын их засварын ажлын төлбөрийн 20% болох 603,861,018 (зуун сая) төгрөг байх бөгөд энэхүү төлбөрт тээврийн зардал, байр, хоол, томилолт, НӨАТ, холбогдох бусад бүх зардал, татвар хураамж багтсан. Энэхүү гэрээгээр тохиролцсон ажил гүйцэтгэхтэй холбоотой бусад шаардлагатай бүх зардлыг Гүйцэтгэгч тал өөрөө бүрэн хариуцна.
- 3.2. Энэхүү гэрээний 3.1-д заасан төлбөрийг дараах журмаар төлнө:
- 3.2.1. Урьдчилгаа төлбөр: Гэрээ байгуулан ажил гүйцэтгэх эхлэхэд **241,544,407** / хоёр зуун дөчин сая / төгрөгийг төлөх; Нэхэмжлэлийн дагуу урьдчилгаа төлбөрийг Гүйцэтгэгчийн Хаан банкны 587638020 тоот дансанд шилжүүлсэнээр ажил эхэлнэ.
- 3.2.2 Үлдэгдэл төлбөрүүд: Гэрээт ажлын явц 40 хувьд хүрсний дараа нь энэхүү гэрээний 3.1-т заасан ажлын хөлсний 25% буюу **150,965,254** (зуун тавин сая) төгрөгийг гүйцэтгэгчээс ирүүлсэн татварын цахим системд үүсгэсэн төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын тав (5) хоногийн дотор гүйцэтгэгчийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг Хаан банкин дахь **5876380205** тоот дансанд шилжүүлнэ.
- 3.2.3. Гэрээт ажлын явц 65 хувьд хүрсний дараа нь энэхүү гэрээний 3.1-т заасан ажлын хөлсний 25% буюу **150,965,254** (зуун тавин сая) төгрөгийг гүйцэтгэгчээс ирүүлсэн татварын цахим системд үүсгэсэн төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын тав (5) хоногийн дотор гүйцэтгэгчийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг Хаан банкин дахь **587638020** тоот дансанд шилжүүлнэ.
- 3.3. Гэрээт ажлын үлдэгдэл буюу баталгааны төлбөрийг энэхүү гэрээний 3.1-т заасан ажлын хөлсний 10% буюу **60,386,101** (жаран сая) төгрөгийг Захиалагчийн комисс хүлээн авсны дараа ажлын тав (5) хоногийн дотор шилжүүлнэ.



ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ


- 4.1. Захиалагч нь Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
 - 4.2. Энэ гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авах, замын ажлын гүйцэтгэлийн төлбөрийг төлөх үүрэгтэй.
 - 4.3. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.
- Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулахыг шаардах эрхтэй.

тав. гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1. Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг өөрөө гүйцэтгэнэ.
- 5.2. Дараах тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:
 - 5.2.1. Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилгаа, даалгавар нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;
 - 5.2.2. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон;
- 5.3. Ажлын үр дүн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг хариуцах үүрэгтэй.
- 5.4. Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу шаардах эрхтэй.
- 5.5. Гүйцэтгэгч нь ажлыг хийж гүйцэтгэх ажилчдаас гадна авто замын инженер-1, хэмжилтийн инженер-1-ийг ажлын талбайд хуваарийн дагуу ажиллуулна.
- 5.6. Ажлыг ажлын даалгаварт заасны дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.
- 5.7. Гүйцэтгэгчийн барьж хүлээлгэж өгсөн ажилд технологийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн чанарын баталгааг хугацаанд гарсан аливаа эвдрэл, гэмтлийг засварлуулах ажлыг Гүйцэтгэгч нь өөрийн хөрөнгөөр хийнэ.
- 5.8. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 5.9. Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад ХАБЭА-тай холбоотой асуудлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцана.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА, ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 6.1. Талуудын аль нэг нь өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол хохирлыг бүрэн хариуцаж арилгах үүрэг хүлээнэ.
- 6.2. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, гэрээний хүчинтэй хугацаанд өөр этгээдтэй давхар гэрээлэхгүй.
- 6.3. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсвэл зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувийн алдангийг Захиалагч талд төлнө. Нийт гэрээнд оногдуулах алдангийн дээд хэмжээ нь Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 5 хувиас хэтэрч болохгүй.
- 6.4. Гэрээг Гүйцэтгэгчээс үл хамаарах бусад шалтгаанаар цуцалсан тохиолдолд Захиалагч Гэрээ цуцлах хүртэл хугацаанд хийгдсэн Ажлын үр дүнгээс хүлээн авах боломжтой эсэхийг шийдвэрлэж тэдгээр Ажлын бодит гүйцэтгэлд тохирох төлбөрийг Зөвлөхөд олгох ба



үүнээс бусад аливаа хохирол, алданги торгууль, төлбөрийг төлөх үүрэг хүлээхгүй.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХАРИЛЦАА ИЛ ТОД, ШУДАРГА БАЙХ

7.1. Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгын хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

7.2. Гүйцэтгэгчийн зүгээс өөртөө давуу тал олж авах зорилгоор Захиалагчийн ажилчид, эрх бүхий этгээдэд мөнгө эсвэл мөнгөн бус хэлбэрээр эд зүйл өгөх буюу амлах, Захиалагчийн Гүйцэтгэгчээ сонгох, хэлэлцээр хийх, гэрээ байгуулах шийдвэр гаргах явцад шударга бус замаар нөлөлөх аливаа үйлдэл гаргасан бол Захиалагч энэхүү Гэрээг нэг талын санаачлагчаар цуцалж, учирсан хохирол зардлаа шаардах, Гүйцэтгэгчид үүсэх үр дагаврын талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй байх эрхтэй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.2. Маргаан, зөрөлдөөнийг эвийн журмаар шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА

9.1. Бүрэн эрх: Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээг байгуулах болон Гэрээний нөхцөлүүдийг биелүүлэхдээ өөрийн эрх бүхий байгууллагаас шаардлагатай бүх зөвшөрлийг авсан байна.

9.2. Үнэн зөв мэдэгдэл: Энэхүү гэрээний дагуу Гүйцэтгэгчээс Захиалагчид гарган өгсөн бүх баримт бичиг болон мэдэгдэл, баталгаа нь бүгд үнэн зөв бөгөөд ямар нэгэн чухал үйл баримтын талаар худал мэдэгдээгүй, Гэрээ үнэн зөв болоход зайлшгүй шаардлагатай аливаа чухал үйл баримтыг орхигдуулаагүй болно.

9.3. Зөрчилдөөн байхгүй тухай: Талууд нь энэхүү Гэрээгээр тохирсон нөхцөлүүдийг биелүүлэх нь Талуудын дүрэм, журам болон ижил терлийн бусад баримт бичгийн нөхцөл болзолтой зөрчилдөхгүй бөгөөд эдгээр нөхцөл, болзлын дагуу аливаа хувь хүн буюу бусад байгууллага, хуулийн этгээдээс зөвшөөрөл авах шаардлагагүй. Одоо байгаа болон ирээдүйд гарч болох аливаа шүүх, захиргаа, арбитрын шийдвэрийг биелүүлж байгаа Талуудын үүрэг нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхэд ямар ч хэлбэрээр саад болохгүй. Талууд нь Гэрээ байгуулсан өдрөөс хойш энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ ямар нэгэн хэлбэрээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

9.4. Санхүүгийн боломж: Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний дагуу Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэртэй болно.

9.5. Туршлага, ажиллах хүч, техникийн боломж: Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу Ажил гүйцэтгэхэд шаардагдах дадлага, туршлага, чадвартай, ажиллах хүч, тоног төхөөрөмжтэй

АРАВ. БУСАД ЗААЛТ

10.1. Энэхүү Гэрээний үүргийг давагдашгүй хучин зүйл (гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүд)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тал нь энэ тухай нөгөө



талдаа нэн даруй мэдэгдэнэ. Давагдашгүй хүчин зүйл үргэлжлэх хугацаанд талууд энэхүү гэрээнд заагдсан үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөнө.

10.2. Энэхүү Гэрээний нууцлалд талуудын санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад холбогдох мэдээ, мэдээлэл, түүнчлэн талуудын зөвхөн өөр хоорондоо харилцан мэдээлсэн тоо баримт, эрх зүйн бичиг баримтууд хамаарах бөгөөд талууд гэрээний нууцлалд хамаарах мэдээ, мэдээллийг нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гуравлагч этгээдэд шилжүүлэх, задруулахыг хориглох ба Нууц хадгалах гэрээг тусад нь байгуулна.

10.3. Гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

10.4. Талууд Гэрээг гурван (2) хувь үйлдэх ба гэрээний хувь тус бүр дээр гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд хувиуд адил хүчинтэй байна.

10.5. Талууд гэрээтэй холбоотой асуудлаар албан бичгээр харилцана.

10.6. Энэхүү гэрээнд тусгагдаагүй холбогдох бусад асуудлыг Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“БИЛЭГТ БАЯЛАГ” ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРАЛ

Э.ЭНХЗАЯА



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ДАЛАН ТУЛГА МАЙНИНГ” ХХК-ийн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.МӨНХТУЛ



ОБЕГ-ын даргын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/75 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

БАТЛАВ:

"БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Э.ЭНХЗАЯА

ЗӨВШӨӨРСӨН:


ОБЕГ-Н ДЭРГЭДЭХ УУЛ УУРХАЙН АВРАХ
АНГИЙН ЗАХИРАГЧ ХУРАНДАА


Д.ГАНТУЛГА

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ "ДАЛАН"
НҮҮРСНИЙ УУРХАЙН
АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ 2025

Үндсэн АТЗ-ын дугаар: MV-021008


ХЯНАСАН:

УУЛ УУРХАЙН АВРАХ АНГИЙН АЛБАНЫ ДАРГА, АВРАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДАГЧ,
АХЛАХ ДЭСЛЭГЧ:  / Y.ТЭМҮҮЖИН /

ХЯНАСАН:

"БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК-ИЙН


АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР:

 / Б.САНДАГДОРЖ /

БОЛОВСРУУЛСАН:

"БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК-ИЙН

ХАБЭАБО-НЫ ИНЖЕНЕР:

 / Ө.АЗЖАРГАЛ /

2025 он

АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
"БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	6
Тайлбар	7
Товчлол	7
НЭГ. ОСОЛ АЮУЛЫН ҮЕД БАРИМТЛАХ БОДЛОГО	8
Компанийн АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ бодлого	8
Зорилго	8
Хамрах хүрээ	8
Ослын үеийн удирлага	8
Ослын үеийн зохион байгуулалт, хариуцлага	9
ХОЁР. ШТАБЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ТОМИЛГОО	10
Штабын нэн түрүүнд хийх ажлын дараалал	10
Хариуцлагатай жижүүр	10
Орлон ажиллах албан тушаалтан	11
Томилгоот бүлэг	11
Ослын газрын удирдагч	11
ГУРАВ. АЖИЛТНЫ ОСЛЫН ҮЕД БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	12
ДӨРӨВ. ОСЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ХҮЧ, НӨӨЦ	18
Аваар осолтой тэмцэх хүн хүч	18
Ослын үед хэрэглэх техник, хэрэгсэл	18
Компанийн галын автомашин	18
Ослын үед хэрэглэх нөөц техник хэрэгсэл	19
Түргэн тусламжийн автомашин, хэрэгсэл	22
Уурхайн бүс дэх нэмэлт хэрэгсэл	22
ТАВ. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СИСТЕМ	23
Системийн тодорхойлолт	23
аялалын үеийн холбоо харилцаа	23
Аваар ослын үед олон нийттэй харилцах	23
Ослын үед шугамын телефон утасны ашиглалтыг хязгаарлах	23
Ослын дараа	23
ЗУРГАА. ОСЛЫН ҮЕД УУРХАЙД МӨРДӨХ ДЭГЛЭМ	24
Хотхон хариуцсан мэргэжилтэн	24
Захиргааны мэргэжилтэн	24
Хотхонд байрлагч	24
ДОЛОО. АВААР, ОСЛЫН ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ	25
Ослын дуудлага өгсөн, ослын газарт байгаа хүн	25
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	25
ИЛ УУРХАЙД ГАРЧ БОЛЗОШГҮЙ ОСЛЫН ТӨРӨЛ	25

Хуудас2/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

оролцох хүн хүч техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах	33
Ээлжийн ахлах	33
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	33
Ослын үед гүйцэтгэх тусгай үүрэг	35
Долоо хоног, сар тутамд хийгдэх аюулгүй ажиллагааны үзлэгийн төлөвлөгөө	36
УУРХАЙН диспетчер	37
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	37
Ослын үед гүйцэтгэх тусгай үүрэг	39
ХАБ-ын мэргэжилтэн	39
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	39
Ослын үед гүйцэтгэх тусгай үүрэг	40
Ослын газрын удирдагч (ОГУ)	40
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	40
Ослын үед гүйцэтгэх тусгай үүрэг	41
УУРХАЙН ДАРГА	42
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	42
Байгаль орчны мэргэжилтэн	42
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	42
Яаралтай тусламжийн нэгж	42
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	42
Онцгой байдлын хэсэг /Гал унтраах баг	43
Ослын үед гүйцэтгэх нийтлэг үүрэг	43
Ослын үед гүйцэтгэх тусгай үүрэг	43
НАЙМ. АЮУЛ ОСЛЫН ҮЕД уурхайд МӨРДӨХ журам	44
1. ТАЛБАЙ ДЭЭР ТҮЛШ АСГАРАХ	44
1.1. Ослын бүсэд байгаа хүн	44
1.2. Ослыг анх харсан ослын дуудлага өгөх хүн	44
1.3. ХАБЭАБО-ны инженер	45
1.4. ХАБ-ын мэргэжилтэн	45
1.5. Уурхайн дарга	45
1.6. Байгаль орчны ажилтан	46
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ОСЛЫН ТОХИОЛДОЛ	46
2.1 Нефтийн бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд	46
2.2 Газар дээр шатахуун асгарсан үед	46
2.3 Усанд шатахуун асгарсан тохиолдолд	46
2.4 Хувийн хамгаалалтын хэрэгсэл	46
Хавсралт №1: Ослыг гадагш мэдээлэх матриц	51
Хавсралт №2: УУРХАЙН ослын газрын удирдагчийн тэмдэглэл	52
Хавсралт №3: Газар хөдлөлийн зэргээс хамааран гарах барилга, байшингийн эвдрэлийн хүснэгт	53
Хавсралт №4: Тэсрэх аюултай материалаас аюулгүй зайд байх удирдамж	54

Хуудас3/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

Хавсралт №5: Ослын үед шийдвэр гаргах албан тушаалтан.....	55
Хавсралт №6: Ослын мэдээлэл хүргэх албан тушаалтны Хаяг	56
Хавсралт №7: Ослын үед холбоо барих байгууллага, албан тушаалтан	57
Хавсралт №8: УУРХАЙД ослын үед ажиллах баг	58
Хавсралт №9: Уурхайд байрлах гал унтраагуурын тоо.....	59
Техникт байрлах галын хор.....	59
Уурхайн объектуудад байрлах гал унтраагуурын тоо.....	59

Хуудас4/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Билэгт Баялаг" ХХК-ийн байгаль орчныг хамгаалах бодлогын гол зорилго нь Монгол улсын "Ашигт малтмалын тухай хууль", "Байгаль орчныг хамгаалах тухай хууль" болон байгаль орчинтой холбогдох бусад хууль, дүрэм, журам, компанийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино.

Манай компани нь MV-021008 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 178.98 га талбай эзэмшдэг бөгөөд 2017 онд хайгуул хийн нөөцөө баталгаажуулж Зүүндалан, Далангийн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-ийг Кэйстоун ХХК боловсруулж 2018 онд батлуулсан.


Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажлыг "Саут Воли" ХХК 2018 онд боловсруулж БОАЖЯ-аар баталгаажуулсан байна. Байгаль орчны аудитын ажлыг эрх бүхий "Грийн сервис" ХХК 2021 онд хийж гүйцэтгэсэн.

Энэхүү биелэлтийн тайланг боловсруулахдаа "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" болон бусад холбогдох эрх зүйн баримтууд, БОНХЯ-ны сайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн А-05 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" зэргийг удирдлага болголоо.

Төсөл хэрэгжиж буй газрын засаг захиргааны харьяалал

Зүүндалан, Далангийн нүүрсний орд нь засаг захиргааны хуваарлалтаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Элдэв багийн нутагт Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Дорноговь аймгийн төв

Сайншанд хотоос баруун хойш 200 км, Даланжаргалан сумын төвөөс баруун хойш 28 км, төмөр замын 25-р зөрлөг болон Улаанбаатар- Сайншандыг холбосон автозамаас 22 км зайд байрлах "Баруундалан" хэмээх газрын зүүн хэсэгт орших ба физик газарзүйн мужлалаар тал хээр-говийн бүст хамаарна. Уг орд нь дэд бүтэц зам харилцаа сайн хөгжсөн, цахилгаан эрчим хүчний төвийн шугам сүлжээнд холбогдсон бүс нутагт оршино.



Хуудас 5/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

Зүүндалан, Далан тусгай зөвшөөрөлтэй талбайн солбилцол

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	108	58	1.63	46	8	11.66
2	108	58	1.63	46	7	51.66
3	108	58	21.62	46	7	51.66
4	108	58	21.62	46	7	31.65
5	108	56	41.63	46	7	31.65
6	108	56	41.63	46	7	51.66
7	108	57	26.62	46	7	51.66
8	108	57	26.62	46	8	11.66

Дэд бүтэц, зам харилцаа

УБ хотоос төмөр замын 25-р зөрлөг хүртэл хатуу хучилттай замаар зорчино. Цааш уурхайн талбай хүртэл автомашинаар зорчихдоо бартаа саадгүй сайжруулсан шороон замын сүлжээтэй.

Уурхайн карьер, хөрсний овоолго, кемп, засварын газрууд нь хоорондоо шороон замаар холбогдсон. Уурхайгаас "МАК" ХХК-ийн сайжруулсан нүүрс тээврийн зам хүртэлх замын даланг уурхайн хөрс хуулалтаас гарсан хөрсөөр хийсэн ба технологийн тээврийн зам нь 20 м өргөнтэй нийт 1.4 км замын суурь нь 0.45 м зузаан, 0,25 метр хайрган хучилттай бөгөөд цаг агаарын байдалд тэсвэртэй, ус урсах боломжтой 100 хүртэл тонны даацтай тээврийн хэрэгслүүд явахад зориулагдсан. Харилцаа холбооны хувьд үүрэн телефоны оператор компаниудын сүлжээ нэвтэрсэн.

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Хуудас6/66



"Билэгт баялаг" ХХК

АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

ТАЙЛБАР

Компани:	"Билэгт баялаг" ХХК. Энэхүү төлөвлөгөөнд цаашид "компани" гэж нэрлэнэ.
Төслийн талбай:	Компанийн уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа эзэмшлийн талбайг бүхэлд нь хамааруулан ойлгоно. Үүнд уурхай түүний барилга байгууламж, хотхон, тэдгээрийн хооронд зорчих зам зэрэг хамаарна.
Гэрээт:	Гэрээт гэдэгт "Билэгт баялаг" ХХК-тай гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэж байгаа үндсэн гэрээт гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч нарыг хамруулан ойлгоно.
Штаб:	Орон Тооны Бус Штаб (ОТБШ) гэдэг нь Осол, аваарын үед төслийн талбайд компанийн болон хамтран ажиллаж байгаа бусад гэрээтийн ¹ шийдвэр гаргах төвшний албан тушаалтныг оролцуулан байгуулсан ослын удирдлагын багийг хэлнэ.
Онцгой байдал:	Онцгой байдал гэж гамшгаас хамгаалах арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг онцгой ажиллагаа явуулж байгаа нөхцлийг
Нэгж:	Компанийн газар, алба, хэлтэс, хэсгийг төлөөлүүлэн ойлгоно.

ТОВЧЛОЛ

АА	- Аюулгүй Ажиллагаа.
АБҮ	- Ажлын Байрны Үзлэг.
ОСТ	- Ослын Судалгааны Тайлан.
ХАБЭА	- Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуй.
ХНҮ	- Хөдөлмөрийн Нөхцөлийн Үнэлгээ.
ҮОХХСБК	- Үйлдвэрлэлийн Осол, Хурц Хордлогыг Судлан Бүртгэх Комисс.
ЭМУСҮ	- Эрүүл Мэндийн Урьдчилан Сэргийлэх Үзлэг.
ББХ	- Билэгт баялаг ХХК.
ЯТН	- Яаралтай Тусламжийн Нэгж
ОГУ	- Ослын газрын удирдагч
СДАБ	- Судлан дүгнэх аврах баг
ГУУХ	- Геологи уул уурхайн хэлтэс

¹ Тухайн осол нь тус гэрээтийн үйл ажиллагааг хамарсан эсэхээс шалтгаалан штабын бүрэлдэхүүнд оруулах эсэхийг уурхайн дарга шийдвэрлэнэ.



НЭГ. ОСОЛ АЮУЛЫН ҮЕД БАРИМТЛАХ БОДЛОГО

КОМПАНИЙН АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Компанийн осол, аваарын талаарх бодлого, төлөвлөгөөний туйлын зорилго нь бүх осол, аваараас урьдчилан сэргийлэх боловч аливаа аваар, осол гарсан тохиолдолд ажилтан түүний гэр бүл, орон нутгийн иргэдэд аль болох хохиролгүй байлгах зорилгоор ослын үеийн бэлэн байдлыг өндөр төвшинд хангаж ажиллана.

Үүний тулд компани "Эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ"-г "Монголын галын инженер, техникчдийн холбоо" ТББ-аар хийлгэж дараах чиглэлээр эрсдэл эмзэг байдлын үнэлгээ хийлгэв. Үүнд:

- ✓ Байгалийн гаралтай гамшгийн эрсдлийн үнэлгээ
 - ✓ Гал түймрийн эрсдлийн үнэлгээ
 - ✓ Газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээ
 - ✓ Техник, технологи, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй аюулын эрсдлийн үнэлгээ
 - ✓ Биологийн гаралтай гамшгийн эрсдэл
 - ✓ Гамшгийн эрсдлийн ерөнхий үзүүлэлт, үнэлгээ
- Гэсэн 6 бүлэг сэдвээр эрсдлийн үнэлгээ хийлгэсэн.

Компани нь уурхайн бүсэд бэлтгэгдсэн аврах багийг бүрэн бүрэлдэхүүнээр ажиллуулна. Мөн томилгоот бүлгэмүүдийг байгуулж шаардлагатай сургалтанд тогтмол хамруулж, идэвхижүүлэн ажиллуулна.

ЗОРИЛГО

Төлөвлөгөөний зорилго нь төслийн талбайд гарч болзошгүй аваар, осолтой тэмцэх хүн тус бүрийн үүрэг хариуцлага, хэрэгжүүлэх журам, дэглэмийг тодорхойлох, осол гарсан үед түүний хор уршгийг шуурхай устгах, бууруулахад оршино.

Энэхүү төлөвлөгөө нь ослын үед ажилтан, удирдлагын гүйцэтгэх ажлын удирдамж болно.

Төлөвлөгөөг шинээр ажилд орсон ажилтан бүрт заавал танилцуулах бөгөөд бүх нэгжийн удирдлага жилд нэг ба түүнээс дээш удаа өөрсдийн хариуцсан ажилтанд танилцуулж хэлэлцсэн байна.

Төлөвлөгөөг ХАБЭАБО-ны хэлтэс жил бүр хянаж компанийн удирдлагын бүтэц, үндсэн үйл ажиллагаа эсвэл энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болох өөрчлөлт гарсан үед засвар хийж шинэчилэн батлуулна.

ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн талбайд ажиллаж байгаа бүх ажилтан, зочин, дадлагажигч нарт нэгэн адил хамаарна.

Хэсэг, нэгжийн удирдлага бүр энэхүү бодлого, төлөвлөгөөг дагаж мөрдөн ослын үед хэрэгжүүлэх, хариуцсан ажилтандаа сайтар ойлгуулан мөрдүүлэх үүрэгтэй.

Ажилтан бүр энэхүү төлөвлөгөөгөөр үүрэг болгосон болон хориглосон заалт бүрийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Энэхүү төлөвлөгөөнд тусгайлан заагдсан албан тушаалын нэршил бүрийн хүлээх үүрэг, хариуцлагыг тухайн албан тушаалтныг эзгүйд орлон ажиллаж байгаа албан тушаалтан хүлээнэ.

ОСЛЫН ҮЕИЙН УДИРЛАГА

Ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний гол шийдвэрийг уурхайн удирдлагын баг дотроос уурхайн дарга, ХАБЭАБО-ны инженер гаргана.

Хуудас 8/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

Бусад нэгжийн удирдлага онцгой байдал үүссэн үед энэхүү төлөвлөгөө болон холбогдох журмаар заагдсан үүргээ хэрэгжүүлнэ.

ОСЛЫН ҮЕИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАРИУЦЛАГА

Уурхайн дарга нь осол аваарын үед Орон Тооны Бус Штаб (цаашид "Штаб" гэх)-ыг яаралтай байгуулна.

Штабыг осол, аваарт өртөхөөргүй, аваарын нөхцөл байдлыг ерөнхий байдлаар нь харах эсвэл хянах боломжтой газар байгуулвал илүү үр дүнтэй бөгөөд штабын байр нь интернет сүлжээ, гар утас, радио зэрэг харилцаа холбоог нэгэн зэрэг ашиглах боломжтой байх шаардлагатай.

Хуудас9/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

ХОЁР. ШТАБЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ТОМИЛГОО

ШТАБЫН НЭН ТҮРҮҮНД ХИЙХ АЖЛЫН ДАРААЛАЛ

Аваар ослын шинж чанар, цар хүрээнээс хамааран уурхай дахь оффисын байрыг Штаб болгон ашиглана.



Штаб нь осол, аваарын хор хохиролыг бууруулах хариу арга хэмжээг зохион байгуулах, шийдвэр гаргах төв байна.

Газар дээрх ахлагч нь штабтай холбогдож мэдээлэл өгөх, заавар чиглэл авах, газар дээрх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг хүлээнэ.

Аливаа ослын үеийн удирдлагын бүтэц нь ерөнхий зохион байгуулалтын схемээр явах боловч тухайн нөхцөл байдалд тохируулан өөрчлөн баталж болно.

ХАБЭА хариуцсан мэргэжилтнийг ирэх хүртэл тухайн нэгжийн ахлах, удирдах ажилтан шийдвэр гаргах бөгөөд түүнийг "Ослын Газрын удирдагч" (ОГУ) гэж нэрлэнэ.

ОГУ-ийн зөвшөөрөлгүй ослын газрыг орхин явахыг хориглоно.

Хариуцлагатай жижүүр

Уурхайн бүсэд хариуцлагатай жижүүрийг баярын амралтын өдрүүдэд уурхайн дарга удирдамжаар томилж ажиллуулах бөгөөд аливаа осол, аваар гарах, онцгой байдал үүсэх зэрэгт газар дээр нь шуурхай арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна. Өөрөөр хэлбэл уурхайн удирдлага нь уурхайд байхгүй үед уурхайн удирдлагын заавар, журмын дагуу газар дээрх удирдлагын үүргийг хэрэгжүүлнэ.

Хүүдас10/66



Орлон ажиллах албан тушаалтан

Уурхайн дарга болон нэгжийн удирдлага уурхайн бүсэд байхгүй тохиолдолд орлон ажиллах албан тушаалтныг заавал томилж үлдээнэ.

Эдгээр нь үйлдвэрлэлийн бүх талбайн аюулгүй ажиллагаа болон жигд үйлдвэрлэлийг томилогдсон хугацаандаа хариуцах бөгөөд онцгой байдал үүссэн, осол гарсан тохиолдолд хариуцах үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байх үүрэгтэй.

Төслийн талбайд гарсан осолтой холбоотой орчны хүн амд сөрөг нөлөөлөл гарч болзошгүй тохиолдолд уурхайн удирдлага бүх хүнд мэдээлнэ.

Томилгоот бүлэг

Осол аваарын үед ажиллах албан тушаалтныг томилгооны хүснэгтээр хавсралт №1-д харуулав.

Ослын үед ажиллах албан тушаалтан осол аваарын үед гарсан үйл явцыг цаг хугацаатай нь хамт тэмдэглэсэн бүртгэлтэй байна. Энэ бүртгэлийн маягтыг журмаар зааж өгнө. Хавсралт №2.

Төслийн талбайд осол, аваар болсон тохиолдолд хавсралт №3-т заасан байгууллагад мэдэгдэнэ.

Ослын газрын удирдагч

Төслийн талбайд гарсан аваар ослын үед ОГУ-аар ХАБЭАБО-ны инженер ажиллана. Ослын нөлөө буурсаны дараа ОГУ осол гарсан шалтгааныг тогтоох ажлыг зохион байгуулж тайлан мэдээг нэгтгэн шаардлагатай сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Ослыг судлан бүртгэх, мэдээ тайлан нэгтгэн хүргүүлэх үйл явцыг "Ослыг судлан бүртгэх журам"-аар зохицуулна.

Аваарын нөхцөл байдал хэзээ ч үүсэж болох бөгөөд доор дурдсан хүчин зүйлсийн аль нэгийг эсвэл хамтын үр дагавар хэлбэрээр байж болдог.

- ✓ Уурхай болон агуулахын гал
- ✓ Дугуй шатах ба буудах
- ✓ Дэлбэрэлт
- ✓ Хордох
- ✓ Онхолдох
- ✓ Мөргөлдөх
- ✓ Дайрагдах
- ✓ Өндрөөс унах
- ✓ Байгалийн гамшигт үзэгдэл

Аваар устгах төлөвлөгөөнд тусгагдаагүй аливаа ослын үед "Онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний схем"-ийг дагаж мөрдөнө.



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

ГУРАВ. АЖИЛТНЫ ОСЛЫН ҮЕД БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Төслийн талбайд гарсан аливаа осол аваарын үед ослын газраас бусад хэсэгт байгаа компанийн болон гэрээтийн ажилтан дараах дарааллын дагуу ажиллах үүрэг хүлээнэ. Үүнд:

1. Өөрийн байгаа газраа хүлээнэ.Өөрийн явуулж байсан үйл ажиллагаагаа зогсоож хүлээнэ.
2. Холбоо ашиглах боломжтой бол өөрийн нэгжийн ахлах, удирдах ажилтан руу холбоо барьж заавар авна. Түүнээс бусад тохиолдолд радио станцыг хүлээх горимд байлгана.
3. Томилгоот бүлгийн гишүүн бол гүйцэтгэх үүргийн талаар зааврын дагуу ажиллана.
4. Амрах байрандаа байгаа ажилтан ослын талаар дуулсан даруй ажлын хувцсаа өмсөж дуудсан цагт тусламж үзүүлэхэд бэлэн байдалд орж заавар хүлээнэ.
5. Нэгжийн удирдлага болон ОГУ-ийн заавар, зөвшөөрөлгүй төслийн талбайд зорчихыг хориглоно.
6. Хүлээх заавар авсан тохиолдолд ажилтан байгаа орчныхоо тайван байдлыг хангах зарчим баримтлан олноор бөөгнөрөн үймэлдэх, маргаан гаргах, болсон тохиолдлын талаар мэтгэлцэх, өөрийн дүгнэлтээр асуудлыг дүгнэх, бусдад нөлөөлөх зэргээр тайван байдлыг алдагдуулах, аврах туслах ажил болон судалгаа шинжилгээний ажилд саад учруулахыг хатуу хориглоно.
7. Ажилтан ослын талаар нийтэд олон нийтэд түгээх, цахим сүлжээнд мэдээлэл, зураг зөвшөөрөлгүй оруулахыг мөн хориглоно.

Ослын газарт байсан, ослыг илрүүлсэн ажилтан болон ослын газарт ажиллахаар томилогдсон ажилтан нар дараах зарчмын дагуу ажиллах үүрэгтэй.

Удирдах ажилтнууд холбогдох онцгой байдал үүссэн үед өөр өөрийн үүргүүдийг хүлээж тухай бүрд нь зохицсон үйл ажиллагааны горимуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

а)Аваар устгах ажилд оролцох хүн тус бүрийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны дараалал Уурхайн захирлын үүрэг

Уурхайн ажилчдын тоог нарядын дэвтэртэй тулган шалгаж, осолд нэрвэгдсэн хүмүүст үзүүлэх эмнэлгийн тусламжийг зохион байгуулж удирдана.

Ерөнхий инженерийн шаардлагаар туршлагатай ажилчид, ИТА-г татан оролцуулж, аваар устгах яаралтай ажил үүрэг гүйцэтгэх хүмүүсийг томилно.

Аваар устгахад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, материалаар хангана.

Аваар устгах ажилд оролцож байгаа хүмүүсийг амрах байр, хоол хүнсээр тасралтгүй хангах ажлыг зохион байгуулна.

Аваар осол гарсан шалтгаан, түүний шинж чанар, аваар устгах явцын талаар удирдах дээд байгууллагад мэдээлнэ.

Ерөнхий инженерийн үүрэг

Шуурхай хэсэгт урьдчилан заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажилд яаралтай орж, түүний биелэлтэд байнгын хяналт тавина.

Хуудас12/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

Аваар устгах ажлыг тодорхой нэг байрнаас удирдаж гүйцэтгүүлнэ.

Осолд нэрвэгдсэн хүмүүсийн тоо, тэдгээрийн нарыдаар ажиллаж байсан газрыг нарийвчлан тогтооно.

Шаардлагатай тохиолдолд УУАА-ыг дуудуулна.

Шуурхай дэвтэр хөтлөх ажлыг инженер техникийн нэг ажилтанд албан ёсоор хариуцуулна.

Аваар устгах ажлын явцын талаар шуурхай мэдээг тогтмол авч хүн бүрийн үйл ажиллагааг байнга хянан, инженер техникийн ажилтан нарыг хариуцлагатай жижүүрт томилон ажиллуулна.

Тусгай хүч томилон харуул хамгаалалт гаргана.

Аваар осол үргэлжлэх төлөвтэй үед инженер техникийн ажилтан, ажилчдыг ажиллах тусгай хуваар гаргана.

Аваар устгах ажлын хариуцлагатай удирдагч - ерөнхий инженер нь удирдах дээд байгууллагуудаас уг асуудлаар заавар, зөвлөмж шаардах эрхтэй.

ХАБЭА-ын инженер

Аваар, осол гарсан газарт ирсэн тухайгаа аваар устгах ажлын хариуцлагатай удирдагч - ерөнхий инженерт биечлэн мэдээлнэ.

Аваар устгах ажлын төлөвлөгөөний дагуу аваар, осол гарсан хэсгээс хүмүүсийг гаргаж, ерөнхий инженерийг ирэх хүртэл аваар устгах ажлыг шууд удирдаж гүйцэтгэнэ.

Аваар устгах ажилд биечлэн оролцох тусгай бригадыг зохион байгуулж тэргүүний дадлага, туршлагатай хүмүүсийг жижүүрт тогтмол томилон ажиллуулна.

Голомтын хэсэгт ажиллахдаа ажилчдыг тайван байлгаж хөдөлгөөн эмх замбраагүй байдалд үүсэхээс ахааруулж аюулгүй байдлын хангаж ажиллах

Цахилгаанчны үүрэг

Ерөнхий инженерийн шийдвэрээр буюу түүний зөвшөөрлөөр цахилгаан гүйдлийг залгах, салгах ажлыг гүйцэтгэнэ.

Нэмэлт цахилгаан шугам татах, шинээр тоног төхөөрөмж оруулах зэргийг хариуцана.

Механик инженер

Өргөх машин механизм, уурхайн цахилгаан болон механик техник, тоног төхөөрөмж, аж ахуйн бусад үйл ажиллагааг хэвийн байлгана.

Гулсалт, нуралт гарсан тохиолдолд ерөнхий инженерийн шийдвэрээр өргөх, ухаж ачих төхөөрөмжүүдийг зайлуулж, анхааруулах таних тэмдэг тавина.

Хуудас13/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

Аваар, ослыг устгах ажлын явцын талаар байнга харилцаа, холбоотой мэдээлж ажиллана.

Уулын инженер, уулын мастерүүдийн үүрэг

Аваар гарсан тухай мэдээ авмагц ерөнхий инженер ба бусад удирдах хүмүүс болон уурхайн эмчид яаралтай мэдэгдэж тэднийг иртэл аваар ослыг устгах, осолд нэрвэгдсэдийг аюулгүй газарт гаргах ажлыг удирдан гүйцэтгэнэ.

Ерөнхий инженер болон бусад удирдах хүмүүсийг ирэхэд аваар, осол гарсан ерөнхий шалтгаан, түүнийг устгах талаар юу хийж байгааг тодорхой илтгэж, удирдах хүмүүсээс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлнэ.

Аваар устгах ажилд оролцох бусад хүмүүсийн үүрэг

Шатахуун түгээгч нь тээврийн ба бусад тоног төхөөрөмжийг түлш, шатахуун, тослох материалаар шуурхай хангах

Ерөнхий инженерийн шийдвэрээр аваар, осол гарсан газраас үнэт эд хогшлыг гаргаж хамгаалалтанд авна.

Аваарийн үед байнга ажлын байранд жижүүрлэж, аваар устгахад шаардлагатай эд материал, запас сэлбэг, багаж хэрэгслийг гаргаж өгнө.

Шаардагдах ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр шуурхай хангана.

Уурхайн эмчийн үүрэг

Осолд нэрвэгдсэн хүмүүст анхны тусламж үзүүлж шаардагдах багаж хэрэгсэл, эм тариа болон бусад зүйлээр хангана.

Эмнэлгийн анхны тусламж үзүүлж, өртөгсдийг эмчилнэ.

Шаардлагатай бол аймгийн түргэн тусламжийг дуудаж, осолд өртөгсдийг зөөвөрлөх арга хэмжээ авна.

Радио холбооны ажилчны үүрэг

Аваар осол гарсан тухай мэдээг хүлээж авмагц зохих байгууллага, холбогдох хүмүүст яаралтай мэдэгдэнэ.

Ослын талаарх мэдээг шууд дамжуулах боломжийг хангана. Аваар устгах ажлыг бүрэн дуусах хүртэл холбоог ажиллуулна.

АЖИЛТАН	БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ
Ослын газар дээрх эхний хүн	1. Яаралтай дуудлага өгнө. /Эмнэлэг, ОБ, ХАБ, Мастер/ 2. Хүн бэртэж гэмтсэн эсэх, галын аюул байгаа эсэхийг тодорхойлно. 3. Ослын газарт шаардлагатай анхны тусламжийг үзүүлнэ.

Хуудас14/66



АВААР УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ "БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК

	<p>4. Яаралтай тусламж үзүүлэх шаардлагагүй бол ослын газарт тусгаарлах арга хэмжээ авч хөдөлгөөнийг хязгаарлана.</p> <p><u>Анхаарах зүйлс:</u></p> <ul style="list-style-type: none"> ✓ Ослыг харсан хүн ОСОЛ-ОСОЛ-ОСОЛ гэж Зудаа хэлнэ ✓ Богино холбоо (станцаар) ээлжийн мастер,ахлах ажилтандаа мэдээлэх ✓ Үүний дараа тэмдэлэл хөтлөж баримтжуулах ажлыг гүйцэтгэх ✓ Ослын төрөл хүн гэмтэх, байгаль орчин асгаралт (ямар төрлийнх тодорхой мэдээлэх) ✓ Хөрс болон усан санд нөлөөлөх эсэх ✓ Ослын мэдээг хамгийн ойрын удирдлагийн хэсэгт мэдээлж дараагийн зааварчилгаа иртэл хүлээнэ. ✓ Үйлдвэр,тоног төхөөрөмж,машин,механизмд осолдсон нөхцөлд цахилгааны бүх тэжээлийг салгах ✓ Асгаралт, гал түймрийн үед зөвхөн салхины дээд талд байрлана. ✓ Өөртөө болон бусдад аюул учруулах нөхцөл байдлаас зайлсхий. ✓ Осол гарсан цаг байршлыг тэмдэглэ. ✓ Ослын хохирлыг өөртөө аюулгүйгээр бууруулах, хязгаарлах боломжтой бол хүн, байгаль орчин, эд хөрөнгөнд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийл. ✓ Ослын талаар мэдээлж, тусламж ирэхэд мэдээлэл заавраар хангахын тулд ослын газар үлдэнэ. ✓ Осолдогч нас барсан нь тодорхой тохиолдолд ослын газрыг 100 метрийн радиуст хөл хорьж тусгаарлах арга хэмжээ авна. ✓ Гэрэлтүүлэг хязгаарлагдмал орчинд ил гал гаргаж гэрэлтүүлэхийг хориглоно.
